



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/50

Хархорин сум

Эзэмшил газрын хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Соёмбо хороолол 5 тоотод байрлалтай Бorigдой ХХК-ний урлаг, соёлын байгууллагын зориулалтаар эзэмшиж байгаа 5000м2 газрыг тухайн зориулалтаар хэмжээ байршил өөрчлөхгүйгээр хэлбэрийг нь өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч "Бorigдой"-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Бorigдой ХХК-ний захирал Ж.Дайрийжав)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын газар эзэмшүүлэх тухай 2016 оны А/106 дугаар захирамж, 0000294245 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

